

ПРОТЕСТАНТ ШАШИН

О. Чимэг- МУИС-ийн Шашин судлалын тэнхмийн дэд профессор

Товч утга: Протестант шашин нь христос шашны гуравдахь том чиглэл бөгөөд зууны Европ дахь Реформацийн үр дүнд үүссэн. Энэ шашны үүсэл, үзэл номлолын онцлог, урсгал чиглэлийн талаар голлон А.Е.Кулаковын гарын авлагад өгүүлснийг эш үндэс болгон авч үзэв.

Түлхүүр үг: үүсэл, үзэл номлол, урсгал чиглэл, лютеран ёс, кальвин ёс,

90-ээд оноос хойш Монголд олноороо орж ирсэн христос шашны олон чиглэлийн ихэнх нь протестант шашинд хамаардаг нь тус шашны онцлогтой холбоотой юм. Дундад зууны үед Баруун Европын орнуудад голлон дэлгэрсэн католик ба Византигаас гаралтай үнэн алдрын /"Orthodox"/ шашин нь XI зууны хагарлын үр дүнд тусгаарласан хэдий ч Ариун номлол хэмээх Библи судраас гадна Ариун уламжлал хэмээх сүм хийдийн бичмэл болон аман уламжлалыг Эзэн тэнгэрийн адистэд хэмээн хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ дундад зуунд хязгааргүй ноёрхож нийгмийн албан ёсны үзэл суртал болж ирсэн байдаг.

Тэгвэл протестант шашин нь XV зууны Европт Реформац буюу Шинэчлэл хэмээх нэрээр түүхэнд орсон нийгмийн болон оюун санааны хөдөлгөөний үр дүнд христос шашны гуравдахь том урсгал болж үүсчээ.

Протестант шашин дотроо маш олон урсгал чиглэлтэй ба эдгээрийн нэлээд хэсэг нь "сект" буюу явцуу бүлэглэл гэсэн нэрээр яригддаг. XVI зууны Европ дахь католик ба протестантуудын хоорондын зөрчил тэмцлийн үр дүнд нэлээд тооны протестантууд өнөөгийн АНУ-д суурьшсан тул ялангуяа АНУ-д протестант шашинд багтах олон урсгал чиглэлийн төв байдаг бололтой юм.

Протестант шашин Европт дэлгэрсэн түүх болон тэр үеийн бичиг баримтын талаар манай түүхчдийн судалгаа бүтээлд тусгагдсан /4/ байхаас гадна христос шашны философичдын үзэл санааны талаар бүтээлүүд /3/ бий. 90-ээд оноос хойш христос шашинтны гол судар "Библи" монгол хэлэнд орчуулагдсан нь протестант шашинд мөн л холбогдоно /2/. Хэдий тийм боловч протестант шашны олон урсгал чиглэлийн талаар христос шашин орж ирээд 20-иод жилийн нүүр үзэж буй манай оронд судалгаа ховор төдийгүй христос шашны аль нэг чиглэлд хамрагдаагүй хүмүүсийн хувьд ойлголт муутай байдаг.

Монголд байгаа чиглэлүүдийн хувьд гол төлөв энд ажиллаж байгаа орос хүмүүст зориулагдсан гэмээр байгаа XIX зуунд анх нээгдсэн гэгдэх оросын үнэн алдрын сүм хийдээс гадна Ватиканы сүм ба өөр зарим нэг католик сүмээс бусад нь бүгд протестант шашинд хамаарах ба энэ нь тус шашны онцлогтой холбоотой юм.

АНУ-ын Юта мужийн Солтлэйк хотод төв нь байх мормоны чиглэл гэхэд л зарим зохиолоос үзэхэд үндэслэгч Жозеф Смит нь өдий төдий эхнэртэй байсан ба олон эхнэртэй байх нь түүний үндэслэсэн шашны онцлог байжээ. Гэвч АНУ-д олон эхнэртэй байхыг тухайн үед хоригложээ. Хэдий тийм боловч насанд хүрээгүй охидуудыг эхнэрээ болгох тохиолдлууд мормонуудын дотор гарах төдийгүй дээрхи асуудалтай холбоотойгоор улангассан үзэлтнүүдийн зүгээс гэмт хэрэг гаргасан тохиолдлын талаар судалгаа бүхий ном зохиол байгаатай /6/ цухас танилцлаа.

Тиймээс дээрхи олон чиглэлийн намтар түүх, сургаал номлолыг судалж, аль нь юу болох, сэтгэл зүйн ямар нөлөө үзүүлэх талаар мэдлэг мэдээлэлтэй болох нь чухал болоод байгааг тэмдэглэхийн сацуу протестант шашны үүсэл, үзэл номлолынх нь онцлогийн талаар энгийн ойлгомжтой хэлбэрээр бичсэн христос шашинт орос орны судлаач А.Е.Кулаковын "Религии мира" /1/ хэмээх гарын авлагад авч үзсэнээр өгүүлье.

Протестант шашны үүсэл

Дундад зууны турш Европын ихэнх оронд хязгааргүй ноёрхож байсан католик шашин сүм хийдийн хэрээс хэтэрсэн эд баялаг, санваартнуудын хуурамч сүсэг, ёс суртахуунгүй үйл ажиллагаа, ялангуяа католик шашин сүм хийдийн орлогын нэг үүсвэр индульгенц хэмээх нүглийн “өршөөл” худалдах практик олны дургүйцлийг төрүүлж байлаа. 1517 онд индульгенц худалдаж олсон хөрөнгийг Ром дахь гэгээн Пётрийн сүм барих ажилд зориулахаар Германы Витенберг хотод доминикан ордоны санваартан ирэхэд тус хотын санваартан, теологийн профессор Мартин Лютер сүмээ хааж индульгенц худалдах үйл ажиллагааг буруушаасан 95 тезисээ хаалганд нь хадаж, эсэргүүцлээ илэрхийлснээр протестант шашны түүх гараагаа эхэлжээ. Үүнийхээ төлөө паап ламд дуудагдсан тэрээр очихоос татгалзсан төдийгүй сүм хийдийн эгнээнээс түүнийг хөөж буй тухай паап ламын булла хэмээх зарлигийг нийтийн өмнө шатаажээ. Түүний сургаалыг Вормс дахь сүм хийдийн чуулганаар буруутгасан боловч тэрээр түүнийгээ хөгжүүлж, сүм хийдийг шинэчилж, анхан үеийн христос шашныг сэргээхийг олон нийтэд уриалсан байна. Сүм хийдийн томоохон теологич / үзэл сурталч / төдийгүй Библийг герман хэлэнд орчуулж герман хэлний хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан, хөгжмийн онолч, хөгжмийн зохиолч байсан Мартин Лютер нь ийнхүү протестант шашин хэмээх христос шашны гуравдахь том урсгалын үүсгэгчдийн нэг болжээ.

1521 онд Лютерийн найз, үзэл санааг нь баримтлагч ба системчлэгч Ф. Меланхтоны боловсруулсан “Аугсбургийн шүтлэг” хэмээх бичиг баримт гарснаар энэ шашин албан ёсны шинжтэй болсон байна. Лютерийн үзэл санааг баримтлагч Ж.Кальвин, Цвингли нар Швейцарт үйл ажиллагаагаа явуулж байсан ба бүр ч радикал бодол санаатай байжээ. Кальвин Швейцарийн чөлөөт хот улс Женевт, Цвингли Цюрихт шашныг шинэчлэх хөдөлгөөнийг толгойлов.

Ж.Кальвин нь бие султай боловч санасандаа тууштай зүтгэдэг, зан авирын хувьд харгис хүн байжээ. Түүний нөлөөгөөр хотын оршин суугчдын бүхий л амьдрал өөрчлөгдөж, архи дарс уух газар цөөрч, хөгжим дуугарахаа больж, бүжиг наадам, үзвэрийн газрууд хаалгаа татаж, мөрийтэй тоглоом хоригдож, гоё, ганган хувцаслах хүн үгүй болсон байна.

Хөдөлмөрч, даруу зан чанар, сүсэг бишрэл ба ёс суртахуун гэсэн Кальвиний дэвшүүлсэн уриан дахь зан чанарууд шинээр үүссэн протестант шашны мөн чанарыг илтгэн харуулах гол онцлог шинж болжээ. Германы алдартай социологич Макс Вебер “Протестант шашны ёс зүй ба капитализмыг хөдөлгөгч санаа” хэмээх алдартай зохиолдоо Баруун Европ, Америкийн өнөөгийн өндөр хөгжил чухам энэ ёс зүйтэй холбоотой бөгөөд шинээр үүссэн протестант шашин нь шинэ соёл иргэншлийн эх үүсвэр болсон тухай санаа дэвшүүлжээ /1, 207-209/. Монголын олон нийтийн дунд 90-ээд онд христос шашныг хөгжил дэвшилтэй холбон ярих явдал үзэгдэж байсан нь протестант шашны талаархи Веберийн үзэл санаанаас гаралтай болов уу.

Цвинглигийн хувьд тэрээр мөн л радикал үзэлтэй байсан ба бүх сүм хийдийг хааж, хурал номын үйл ажиллагааг болиулж, сүм хийд дэх уран зургийн эд хэрэглэгдэхүүн, хурал номын үеийн хөгжим зэргийг таслан зогсоосон байна. Цвингли нь Лютерийг ч тууштай бус байна хэмээн шүүмжилж байсан ба католикуудтай байлдаж байсан протестант цэргийн хамт санваартны хувьд явж байгаад алагдсан байна /1, 209-210/.

Протестант шашныг Европын орнуудын нийгэм, төрөөс шууд хүлээн зөвшөөрөөгүй XVI зуунд шашны дайн болж, шинэ шашныг тогтоох гэж багагүй цус асгаруулсан байна.

Герман дахь шинэчлэх хөдөлгөөн 1524-1529 онд тариачны дайныг төрүүлсэн ба удирдагч нь Томас Мюнцер байв. Удаан хугацааны мөргөлдөөний эцэст 1555 онд Аугсбургийн гэрээнд гарын үсэг зурж, Германы вант улс бүр шашин шүтлэгээ сонгох эрхтэй болжээ /4/.

Францад католик ба протестант шашныхны хоорондын тэмцэл удаан хугацаанд үргэлжилж, ихээхэн цус асгаруулсан ба харгислалын бэлгэ тэмдэг болж түүхэнд орсон

Варфоломейн шөнө /гэгээн Варфоломейн өдөр/ 1572 оны VIII сарын 24-нд Парист 30 мянга орчим протестантууд алагджээ. Тэнд протестантуудыг холбоотон гэсэн герман үгнээс гаралтай гугенот хэмээх нэрээр нэрлэж байсан ба тэдний толгойлогчдын нэг болох Наваррын хаан Генрих Бурбон Францын хааны дүү Маргарита Валуатай гэрлэхээр ирэхэд Маргарита Валуагийн эх, католик шашныг хатуу баримтлагч Екатерина Медичи хуримд оролцохоор ирсэн хүмүүсийг урьдчилан бэлдэж ийнхүү алжээ. Генрихийн хувьд тэрээр хожмоо Францын хаан болсон байна. Дээрхи үйл явдал католикуудын бүрэн ялалтанд хүргэсэнгүй. 1586 онд гугенотууд шүтэж бишрэх эрх чөлөө олж авсан боловч хожмоо дахиад хоригджээ /1,212-213/. Англид протестант шашин тогтох явдал энхийн замаар хаадын дэмжлэгтэйгээр явагдсан. Европын бусад оронд католик шашин нөлөөгөө хадгалж үлджээ.

Протестант шашны үзэл номлол

Протестант шашны удирдлагын зэрэг дэв ба урсгал чиглэлийн сургаал номлол ихээхэн ялгаатай боловч нийтлэг шинж нэлээд ихтэй байдгийг А.Е.Кулаковын номонд өгүүлснээр толилуулъя. Үүнд:

1. Католик болон үнэн алдрын сүм хийд Ариун номлол буюу Библи ба Ариун уламжлал буюу сүм хийд, хурал номын тухай сургаал болон гэгээнтнүүдийн амьдрал үйл ажиллагаа, сүм хийдийн эцэгчүүдийн ном зохиолыг аль алиныг нь шашны асуудлаархи тулгуур үнэний хэмжээнд хүлээн зөвшөөрдөг бол протестант шашинд зөвхөн Ариун номлолыг хүлээн зөвшөөрдөг байна. Өөрөөр хэлбэл, католик ба үнэн алдрын ёсонд эзэн тэнгэрийн бошгоор бичигдсэн Библийг төдийгүй сүм хийд оршин тогтнож ирсэн удаан хугацааны туршид бичмэл буюу аман хэлбэрээр боловсруулан хуримтлуулсан бүхнийг тулгуур үнэний хэмжээнд хүлээн зөвшөөрдөг бол протестант шашинд Ариун номлолыг тэнгэрийн адистэд хэмээн хүлээн зөвшөөрөх боловч Ариун уламжлалыг хүний бүтээл төдий учраас туйлын үнэнд тооцдоггүй байна.

Дээрхээс хийж болох дүгнэлт гэвэл, уламжлалт сүм хийд болох католик ба үнэн алдрын ёс нь протестант шашинтай харьцуулахад “Ариун уламжлал” буюу олон зууны туршид хуримтлуулсан сүм хийдийн бичмэл ба аман өв, сүм хийдийн нэр хүндийг илүүд үздэг.

2. Хүн мөргөл залбирал хийж, зан үйл явуулж, сүм хийдийн үйл ажиллагаанд зориулсан хандив зэрэг буянт үйлээр аврал олохгүй төдийгүй лам санваартны адистэд ч авралын замд тус болохгүй. Хүн юуны өмнө хувийн сүсэг бишрэлээр аврагдана. М.Лютерийн томъёолсон протестант шашны гол үзэл номлол “сүсэг бишрэлээр зөвтөх” тухай агуулгатай байв.

3. Хүн ба эзэн тэнгэрийн хооронд хэн ч зууч болж болж чадахгүй. Эзэн тэнгэрт хүрэх замаа хүн бие даан олох чадвартай. Өөрөөр хэлбэл, ямар ч хүн тэнгэрийн адистэдийг хүртэх боломжтой бөгөөд хэн ч санваартны үүргийг гүйцэтгэж болно.

Протестант шашинтан хүний хувьд пастор /хоньчин/ буюу лам хүн гэдэг бол нийгэмлэгийн удирдагч, хамгийн мэдлэгтэй хүн, хурал номыг зохион байгуулагч бөгөөд “Ариун номлол” буюу Библийг сайн мэддэг хүн болохоос биш католик буюу үнэн алдрын шашных шиг апостолуудын /Христийн шавь нарын / адистэд бүхий хүн биш юм.

4. Протестант шашинтнууд хавьгүй цөөн, ихэнх тохиолдолд хоёрхон нууц ёслолыг хүлээн зөвшөөрдөг ба тэр нь загалмайлах ба нанчид хүртээх зан үйл юм. Эдгээр нууц ёслолыг протестант шашинтнууд далдын, нууц, таньж мэдэгдэшгүй утга агуулгатай гэж үзэхгүй, гагцхүү бэлгэдлийн утга агуулгатай гэж үзнэ. Жишээ нь үнэн алдартнууд нанчид хүртэхдээ Христийн бие, цус талх, дарс болж хувирсан гэж итгэдэг бол протестант шашинтанд энэ ёслол нь Христийг сануулсан бэлгэдлийн утгатай байдаг.

5. Протестант сүм хийдэд Христийн эх, гэгээнтнүүдийн тахилга байдаггүй, эдгээр тахилгыг хүний зохиосон зүйл гэж үздэг.

6. Зан үйл маш энгийн, зарим урсгалуудад үгүй шахам.

Сүм хийдийн барилга ч маш энгийн, ердийн өрөөг ч ашиглаж болно. Христийн болон гэгээнтнүүдийн зураг хөрөг /икон/, баримал байхгүй. Харин хөгжим хэрэглэх бөгөөд хурлын хөгжмийн бүтээлүүд дотор алдартай бүтээл олон бий.

Хурал номын тухайд протестант шашны урсгалууд ихээхэн ялгаатай байдаг: зарим урсгалууд хурал номын үйл ажиллагааг бүрэн үгүйсгэдэг бол зарим нь тусгай уншлагатай байхаас гадна хурал номын үйл ажиллагаа явуулах нарийн дүрэм журамтай.

7. Протестант шашинд сүм хийдийн зэрэг дэв байхгүй. Протестант шашин маш олон урсгал, сект, бүлэгт хуваагдаж, нэгдмэл удирдлага байдаггүй явдал энэ урсгалын чухал онцлог юм.

Хүн өвөрчлөндөө үнэ цэнэтэй, бие даах чадвартай гэсэн төсөөллийг энэ шашинд тулгуур болгодог учраас сүсэг бишрэлийн асуудлыг бие дааж шийдвэрлэх эрхтэй байдаг байна. Энэ үзэл нь протестант шашин сүм хийд байнга хагаралд орж, олон жижиг урсгал, салбар болж хуваагдахад хүргэдэг байна. Үнэн алдрынхан үүнийг нь дур зоргоороо авирлаж байгаагаас нь Эзэн тэнгэрээс үзүүлж буй шийтгэл гэж үздэг байна.

8. Протестант шашинд хүн бүр Ариун номлолыг уншиж, тайлбарлах эрхтэй. Номлолоо тайлбарлах эрх чөлөөнөөс нь үүдэн шинээр төрөөд байдаг сектүүд нь ортодоксаль христос шашнаас улам холдон, гол агуулгыг нь улам умартахад хүргэдэг.

9. Протестант шашны бас нэг онцлог гэвэл сүм хийдийн амьдрал ба ертөнцийн амьдралын хооронд зааг ялгаа бага байдагт оршино. Шашны баяр ёслолын тоо католик ба үнэн алдрын шашныхаас хавьгүй цөөхөн, иргэний ёслолтой нийлмэл байдаг.

Протестант шашинд миссионерүүдийн /латин хэлний missio-үүрэг даалгавар, элч болох явдал/ үйл ажиллагаа, өөрөөр хэлбэл шашнаа дэлгэрүүлэх үйл ажиллагаа маш идэвхтэй, давшингуй шинж чанартай байдаг. Протестант шашны урсгалууд орчин үеийн амьдралд уян хатан зохицох чадвартай, бүх улс түмэн, үндэстнүүдийн дотор дэмжигчидтэй болох эрмэлзэлтэй байдаг ажээ.

Бүхэлд нь авч үзвэл протестант шашин нь далдад итгэх явдалгүй, лам санваартангүй, энгийн зан үйл, хурал номтой, хөдөлмөрч, даруу, арвич, хямгач, ёс суртахуун сайтай зан чанарыг урамшуулсан үзэл сурталтай шашин юм. Протестант шашин нь ертөнцийн бодит амьдралыг зохион байгуулах чиг баримжаатай бөгөөд үнэн алдрын болон католик шашинтай харьцуулахад сүм хийдийн болон ертөнцийн амьдрал нь зааг ялгаа багатай байдаг.

Эдгээр бүх зарчмууд феодалын төвлөрсөн католик сүм хийдийн хүчирхэг захиргааны эсрэг чиглэж байсан байна. Протестант шашин нь шүтлэгийн үйл ажиллагааг сүм хийдээс хувь хүн рүү хандуулж, сүм хийдийн байгууллагыг задалж, Хойд Европын улс орнуудыг паап ламын эрх мэдлээс гаргажээ.

Протестант шашин нь анхнаасаа хэд хэдэн урсгал, сүм хийд болж хуваагдсан бөгөөд тэр хөрсөн дээр өнөөг хүртэл шинэ шинэ сектүүд үүссээр байдаг байна /1,210-216/.

Протестант шашны урсгал чиглэл

Протестант шашин Герман, Скандинавийн орнуудаас гадна АНУ-д хүчтэй байдаг нь АНУ-д Европын орнуудад хавчигдан зугадсан протестантууд голлон нутагшсантай холбоотой юм.

Лютеран ёс. Протестант сүм хийдийн томоохон нь Лютерийн сургаалд тулгуурладаг лютеран сүм хийд ба Герман ба Скандинавийн орнуудад голлон дэлгэрсэн байдаг. Гол номынх нь нэг "Аугсбургийн шүтлэг".

Лютер нь шинэчлэгч байсан боловч түүний сургаал, реформуудад уламжлалт католик шашны нөлөө нэлээд хэмжээнд хадгалагджээ.

Лютеран шашинд тусгай дэг ёс бүхий хурал номын үйл ажиллагаа байх ба хурлын уншлага байдаг. Месса хэмээх гол хурал ном ба хоёр нууц ёслол бий. Сүмд гэр бүл болох ёслол, сахил хүртэхэд адис хүртээх, өвчтэй болон нас барж буй хүнд

зориулсан зан үйл, нүглээ наминчилж ламд өчих, конфирмац буюу миро тосон түрхлэг хүртэж сүм хийдийн гишүүн болж насанд хүрч байгааг бэлгэдсэн зан үйлүүд хадгалагдсан байдаг. Гэхдээ эдгээр элементүүд нь лютеран шашинтны хувьд уламжлалын утгатай болохоос биш, нууц ёслолын шинжтэй байдаггүй. Сүм нь кирх гэсэн нэртэй. Рок хөгжмийн зохиолууд байдгийн нэг жишээ "Исус Христос супер од" хэмээх рок дуурь юм.

Кальвин ёс. Швейцар болон Нидерландад дэлгэрсэн кальвин ёс нь лютеран ёстой харьцуулахад илүү радикал шинж чанартай. Сүсэгтнүүд нь хатуу зарчимтай, энгийн, илүү дутуу юм хөөцөлдөхгүй, амьдрал үйл ажиллагаагаа нарийвчлан зохион байгуулж аж төрөх ёстой байдаг. Энэ нь Кальвины дэвшүүлсэн "хувь заяа бүрэн заагдсан" байдаг тухай үзэл номлолтой холбоотой бөгөөд түүний дагуу хүний сүсэг бишрэл, үйл ажиллагаа үхлийн дараах хувь заяанд нь нөлөөлж чадахгүй гэсэн үг. Хувь заяаг Эзэн тэнгэр нэгэнт заасан байх боловч хүн өөрөө энэ талаар мэдэхгүй. Тэгвэл хүн хичээгээд яах юм гэсэн асуудал тавигдаж болно. Хариулт нь юу байх вэ гэвэл кальвин ёстнууд хүний ажлын амжилт түүнийг Эзэн тэнгэрийн адистэдтэй болохыг харуулна. Тийм учраас кальвин ёстнууд өрсөлдөх, арвилан хэмнэх, хуримтлуулах эрмэлзэлтэй байдаг. Эдгээр зан чанаруудыг капиталист нийгэм-эдийн засгийн системийн хөгжилд тус дөхөм үзүүлсэн хэмээн үздэг ба ийм үзэл Макс Веберийн үзэл баримтлалд анх тусгалаа олсон.

Гэвч Кальвинаас хойш энэ шашны радикал шинж чанар зөөлөрсөн ба орчин үеийн Нидерланд гэхэд л энэ ёстой төдийлөн таарахааргүй олон үзэгдлийн жишээ болж яригддагийг дурьдууштай.

Бусад. Англид VIII Генрих хааны үеэс англикан ёс тогтсон ба энэ нь паап ламын нөлөөнөөс гарах ашиг сонирхлоос улбаатай байв. Түүний охин Елизавета /орос дуудлага, англиар бол Элизабет/ тэр бодлогыг нь үргэлжлүүлжээ.

Шотландад пресвитерийн ёс дэлгэрсэн байдаг. Шинэчлэлийн үед болон хожим хойно ноёрхогч католик сүм хийдээс олон сектүүд /явцуу бүлэглэлүүд/ тусгаарласан ба заримыг нь дурдвал анабаптист, моравын ахан дүүс, квакер, методист, баптист, меннонит, мормон болон бусад олон бөгөөд АНУ-д олноороо дэлгэрсэн байдаг.

Католик шашин хадгалагдсан орнууд. Харин католик шашин нь төвлөрсөн зохион байгуулалтаа хадгалж үлджээ. Өнөө үед католик шашин Өмнөд ба Баруун Европын ихэнх оронд, мөн Латин Америк даяар дэлгэрсэн байдаг. Испани, Португаль, Итали, Бельги, Австри, Польш ба Латин Америкийн орнууд католик шашин ноёрхдог ба Франц, Унгар, Чех, Словак, хуучин Югославийн бүрэлдэхүүнд орж байсан Словен, Хорват, Германы өмнөд ба баруун хэсгүүдэд, Хойд Албанид давамгайлдаг ба Швейцар, Англид ч католикууд байх ажээ. Үүнээс гадна хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд орж байсан Балтийн тэнгисийн орчмын Литв, Латви, АНУ, Канадад католикууд байхын зэрэгцээ Африк, Ази, Их далайн орнуудад католик ёсонд орсон хүмүүс нэлээд байдаг байна / 5 /

Abstract:

Protestant religion is the third main direction of Christianity. Here are considered beginnings, dogma and main directions of this religion as represented in Kulakov's book 'World Religions'.

Ном зүй

1. Кулаков А.Е. Религии мира. М., 1996.
2. Библи. Шинэ гэрээ. УБ., 1996.
3. Бунийхны Ц.Гомбосүрэн. Христос шашны орчин үе дэх философи чиглэлүүд. УБ., 2001.
4. Гонгоржав У. Эрдэнэ-Өлзий Д. Дундад зууны түүхийн унших бичиг. УБ., 1989.
5. Токарев С.А. Религия в истории народов мира. М., 1986.
6. Krakauer Jon. Under the Banner of Heaven. A Story of Violent Faith. USA, 2003.